



ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

Аудитын нэр: ЦЭНГЭГ УС ААТҮГ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

Аудитад хамрагдсан жил: 2023-2024 он

**АУДИТ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГА: СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР**

АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА: “ЦЭНГЭГ УС ААТҮГ”

АУДИТ ХИЙГДСЭН ОБЪЕКТ: “ЦЭНГЭГ УС ААТҮГ”

АУДИТЫН ТӨРӨЛ: ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АУДИТ

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА: 2025.02.03-2025.04.18

АУДИТАД ХАМРАГДСАН ХУГАЦАА: 2025

Тайланг бэлтгэсэн:

**Дотоод аудитын нэгжийн
удирдлагын дарга**

Сэлэнгэ аймгийн Санхүүгийн
хяналт, дотоод аудитын газрын
дарга, СХШУАБ Т.Одсүрэн

Аудитын багийн гишүүн:

Дотоод аудитор Г.Дорждэрэм,
Дотоод аудитор Д.Ванчигмаа

Огноо: 2025 оны 04 дүгээр сарын
18 өдөр

Сүхбаатар сумын 2 дугаар баг,
Нутгийн удирдлагын II байр

selenge@sankhuuaudit.se.gov.mn

1. ТАНИЛЦУУЛГА

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ,

2.1. Аудитын зорилго

2.2 Аудитын цар хүрээ

2.3. Аудитын арга аргачлал, хязгаарлалт

3. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА

3.1 Засаглалын талаар

3.2 Эрсдэлийн удирдлагын талаар

3.3 Дотоод хяналтын талаар

4. АУДИТЫН ҮР ДҮН

4.1 Илэрсэн асуудлууд

5. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

1. ТАНИЛЦУУЛГА

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 оны нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, 14.2.10, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, “Дүрэм батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм”, Дотоод аудитын хорооны 2025 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан 2025 оны хяналт шалгалтын төлөвлөгөөг аймгийн Засаг дарга бөгөөд Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01 дугаартай удирдамжийн хүрээнд Сэлэнгэ Цэнгэг ус ААТҮГ-ын үйл ажиллагаанд дотоод аудитыг хийж гүйцэтгэлээ.

Дотоод аудитыг Засгийн газрын 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийг тус тус үндэслэн санхүүгийн хяналт шалгалт, эрх зүйн нийцлийн чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ба 2023, 2024 оны үйл явцыг хамруулан, дахин тооцоолох, тулган шалгах хяналтын горимыг ашиглах, холбогдох ажилтнуудтай ярилцах, дотоод хяналтын орчныг судлах, үнэлэх, ажил гүйлгээг батлах, хянах, бүртгэх, тайлагнах процессын эрсдэлийг үнэлэх, мөрдвөл зохих хууль тогтоомжийн зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн байдлыг бодитоор илэрхийлж тогтоох, зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдсөн байдал, практикт нийцэж байгаа байдлыг шалгуур үзүүлэлтээр тодорхойлж ажиллав.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго:

Сэлэнгэ Цэнгэг ус ААТҮГ-ын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцуудын үр нөлөөтэй байдлыг үнэлж дүгнэх, тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө өгөх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой.

2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Авлигын эсрэг хууль
- Төсвийн тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль
- Усны тухай хууль
- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 57 дугаар

- тогтоолоор "Сэлэнгэ аймгийн "Сэлэнгэ цэнгэг ус" ААТҮГ-ын цэвэр, бохир усны үйлчилгээний суурь хураамж батлах" тухай тогтоол
- СТОУС, НББОУС болон бусад стандартууд
 - "Цэнгэг - Ус" ААТҮГ-ын дүрэм
 - Бусад хууль, эрх зүйн актууд

Аудитын хамрах хүрээний хязгаарлалт:

Цэнгэг-Ус ААТҮГ-ын 2023, 2024 оны үйл ажиллагааны хамрах хүрээнд хязгаарлалт байхгүй болно.

2.3 Аудитын арга, аргачлал

Дотоод аудитын мэргэжлийн практикийн Олон улсын стандарт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм", Монгол улсын сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 268 дугаар тушаалаар батлагдсан "Улсын салбарын дотоод аудитын аргачлал"-ын дагуу үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэн албан тушаалтнаас асуулга тодруулга авах, нотлох зүйлсийг нягтлах, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх горимуудыг ашиглав.

2.4. Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, журам, дүрэм, зааврыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- ✓ Компанийн тухай хууль
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- ✓ Авлигын эсрэг хууль
- ✓ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- ✓ Нийтийн албанд нийтийн болон хувийг ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ✓ Татварын ерөнхий хууль
- ✓ Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам".
- ✓ Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам".
- ✓ Хот, суурины ус хангамж ариутгах татуургын ашиглал үйлчилгээг зохицуулах хорооны 2024 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан "Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээний тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага"

- ✓ Сэлэнгэ аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 61 дугаар тогтоолоор баталсан Орон нутгийн өмчийн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрэм

3.1 Байгууллагын сайн туршлага

“Цэнгэг - Ус” ААТҮГ нь ӨНС-ийн 6 кВ-ын агаарын шугамын тулгуур болох 27 тулгуур, 6 анкерыг, усан хангамжийн төв шугам сүлжээний хуучирсан, шинэчлэх шаардлагатай хаалтууд болох Ф80-1ш, Ф100-6ш, Ф150-13ш, Ф200-2ш, Ф300-4ш нийт 26 ширхэг хаалт арматурыг сольж шинэчилсэн байна.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 280 сая төгрөгийн өртөгтэй өрмийн машинтай болсон.

Улсын төсвийн хөрөнгөөр 1, өөрийн хөрөнгөөр 4 ус түгээх худгийг ухаалаг системд шилжүүлж шугам сүлжээг шинэчлэн сайжруулсан байна.

УБТЗ-тай хамтран 2-р өргөх насосын станцаас хэрэглэгчдэд түгээдэг төмөр замын депогийн доогуурх 25 метр цэвэр усны шугамыг шинэчилж, гаргалгааг өөрчилсөн нь яаралтай болон аваарын нөхцөл байдал үүссэн үед цаг тухай бүрд тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг шуурхай хийх боломжийг бий болгосон байна.

3.2 Засаглалын талаар

Сэлэнгэ Цэнгэг ус ААТҮГазар нь 1931 онд анх Сэлэнгэ аймаг байгуулагдахад “Нийтийн үйлчилгээний товчоо, хот тохижилт” нэртэй байгуулагдаж 1972 онд НААҮ-ний яам байгуулагдахад гар урлалын артелиар хүрээгээ тэлсэн. Монгол Улсын Дэд бүтцийн яамны сайдын А/100 тоот тушаалаар 1997 онд ОСНААҮ-ний “Дэвшил” компани, Усны аж ахуйн “Урсгал” Улсын үйлдвэрийн газрыг нэгтгэн, хотын усан хангамж, бохир ус зайлуулах, орон сууцны ашиглалт, уст цэг гаргах, засвар үйлчилгээ хийх чиг үүрэг бүхий “Урсгал” УҮГ-ыг байгуулсан байна.

Сэлэнгэ аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2005 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 78 дугаар тогтоолоор НАА-н “Урсгал Ус” ХХК болсон, 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 61 дугаар тогтоолоор “Сэлэнгэ Цэнгэг Ус” ААТҮГ болон шинэчлэгдэж, өнөөдөр 80 гаруй ажилтантайгаар 24 цагийн турш тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна.

3.3 Эрсдэлийн удирдлагын талаар

Байгууллагын эрсдэлийн удирдлагын тогтолцоо төлөвшөөгүй, удирдлага болон ажилтан албан хаагчид эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах талаар мэдлэг, чадвар дутмаг байна. Эрсдэлийн мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргалтад ашиглах механизм бүрдээгүй байгаа нь удирдлагын үр нөлөөтэй шийдвэр гаргахад сөргөөр нөлөөлж байна.

Байгууллагын эрсдэлийн удирдлагын төлөвшлийг тодорхойлоход эрсдэлийн соёл, эрсдэлийн засаглал, эрсдэлийн үйл явц эхлэлийн буюу 1-р түвшинд байна. Иймд “Цэнгэг-Ус” ААТҮГ-ын даргад байгууллагын уламжлалт болон урьдчилан тооцоолсон эрсдэлийг бүртгэж түүнийг бууруулах, урьдчилан сэргийлэх төлөвлөгөө

боловсруулан, хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцох чиглэлээр арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг өгч байна.

3.4 Дотоод хяналтын системийн талаар

Сэлэнгэ Цэнэг Ус ААТҮГ-ын дотоод хяналт хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт нь Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам" болон Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 61 дүгээр тогтоолоор баталсан Сэлэнгэ Цэнэг Ус ААТҮГ-ын дүрмийн 7.1-д "Үндсэн үйл ажиллагааны болон санхүүгийн үйл ажиллагааг хянах дотоод хяналттай байна. Дотоод хяналтын бүтэц, ажиллах журмыг дарга батална" гэж заасан байна.

Гэвч аудитад хамрагдах 2023-2024 онуудад дотоод хяналт чиг үүргийг хариуцах албан тушаалтан тодорхойгүй, дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөгүй, дотоод хяналт шалгалт хийгдээгүй бөгөөд 2024 оны 12 дугаар сарын 9-ны өдөр захирлын тушаалаар дотоод хяналтын ажилтан томилсон байна.

Энэ нь байгууллагын засаглалыг сайжруулах, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх боломжийг алдагдуулж, үйл ажиллагааны ашигт ажиллагааны үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

4. АУДИТЫН ҮР ДҮН

Илэрсэн асуудал 1	Албан томилолтын зардалд 2023 онд 500.0 мянган төгрөг, 2024 онд 2,000.0 мянган төгрөг, нийт 2,500.0 мянган төгрөгийн зарцуулалтыг нотлох хангалттай, зохистой анхан шатны бүрдэл хангасан баримтгүй байна
Асуудлын ангилал	Нөлөө их
Бодит байдал:	Томилолтын зардлыг тулган баталгаажуулахад: Томилолтын зардалд 2023 онд 500.0 мянган төгрөг, 2024 онд 2,000.0 мянган төгрөг, нийт 2,500.0 мянган төгрөгийг зарцуулсан нь анхан шатны баримтаар /томилолтын хуудасгүй, удирдамж, тайлан/ нотлогдохгүй байна
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх"
Асуудлын үндсэн шалтгаан:	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бодлогын баримт бичиг болон холбогдох дүрэм журмаа мөрдөж ажиллаагүй. Байгууллагын нягтлан бодох бүртгэлд тавих хяналт сул байна Санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллаагүй.
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:	Төсөвт үр ашиггүй зардал үүсэх, хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилт хангагдахгүй байх
Шийдвэр:	Албан томилолтын зардалд зарцуулсан 2,500.0 мянган төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт хүргүүлэхээр шийдвэрлэв.

<u>Илэрсэн асуудал 2</u>	Аймгийн Засаг даргаар батлуулсан санхүүгийн төлөвлөгөөний албан томилолтын зардлыг 2023 онд 8,476.0 мянган төгрөгөөр, 2024 онд 12,659.6 мянган төгрөгөөр, нийт 21,135.6 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их
Бодит байдал: Томилолтын зардлыг тулган баталгаажуулахад: 2023 онд 14,033.0 мянган төгрөгөөр төлөвлөгөө баталсан боловч 22,509.0 мянган төгрөгийн зарцуулж батлагдсан төсвийг 8,476.0 мянган төгрөгөөр, 2024 онд 26,400.0 мянган төгрөгөөр төлөвлөгөө баталсан боловч 39,059.6 мянган төгрөгийг зарцуулж батлагдсан төсвийг 12,659.6 мянган төгрөгөөр, 2023, 2024 онд нийт 21,135.6 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна. Энэ төлөвлөснөөс илүү зардлыг гаргаж үр ашиггүй зардал нэмэгдүүлсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах"-гүй, аймгийн Засаг даргын баталсан 2023, 2024 оны "Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө"-г хэтрүүлэн зарцуулсан байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.Захирал дараах эрх, үүрэгтэй: 20.1.3-т "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", аймгийн Засаг даргын баталсан 2023, 2024 оны "Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө"-г хэтрүүлэн зарцуулсан байна.	
Асуудлын үндсэн шалтгаан: Батлагдсан "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтгүй.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Байгууллагын үйл ажиллагааны үр ашиггүй зардал нь ашиг, алдагдалд сөргөөр нөлөөлнө	
Шийдвэр: Цаашид аймгийн Засаг даргаар батлуулсан санхүүгийн төлөвлөгөөний дагуу зардлын ангиллыг хэтрүүлэхгүй байх албан шаардлага хүргүүлж байна	

<u>Илэрсэн асуудал 2</u>	Санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуагүй, хүчин төгөлдөр бус 114,028.3 мянган төгрөгийн ажил гүйлгээний зарцуулалтыг 2023 оны бүртгэл тайланд тусгасан байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө ихтэй
Бодит байдал: Анхан шатны баримтыг тулган баталгаажуулахад: Нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийн бүрдүүлэлт хангалтгүй байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Хангамжийн материалын 39,321.5 мянган төгрөгийн 8 орлогын баримтад бэлтгэн нийлүүлэгчийн гарын үсэг дутуу, - Сэлбэг материалын 35 орлогын баримт, 48 зарлагын баримт дээр гарын үсэг дутуу, 	

<ul style="list-style-type: none"> - 81 шаардах хуудас ерөнхий нягтлан бодогчийн гарын үсэггүй, - Шатахууны материалын 22 жолоочийн тайлан, 24 шаардах хуудсан дээр гарын үсэг дутуу, нийт 114,028.0 мянган төгрөгийн үнэ бүхий баримтууд дутуу бүрдсэн байна.
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д " Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." 13.5."Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна". 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ыг тус тус зөрчсөн</p>
<p>Асуудлын үндсэн шалтгаан: Байгууллагын дарга, ерөнхий нягтлан бодогч нар нь нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтгүй, хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөж ажилладаггүй, хариуцлагагүй байна.</p>
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх. Төсвийн сахилга бат суларч, хариуцлага алдагдах эрсдэлтэй</p>
<p>Шийдвэр: Цаашид анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.</p>

Илэрсэн асуудал 4	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын үйл ажиллагааны онцлог, стандарт, хууль, тушаал, зааварт нийцэхгүй байна.
Асуудлын ангилал	Нөлөө их
<p>Бодит байдал: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2009 онд боловсруулан баталж, мөрдөж эхэлсэн боловч түүнээс хойших хугацаанд Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС)-д орсон өөрчлөлт, шинэчлэлийг тусган шинэчлэх арга хэмжээ аваагүй байна. Энэ нь байгууллагын бүртгэлийн бодлого цаг үеийн шаардлага, стандартын өөрчлөлттэй нийцэхгүй байна.</p>	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана"</p>	
<p>Асуудлын үндсэн шалтгаан: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын үйл ажиллагааны онцлог, стандарт, хууль, тушаал, зааварт нийцэхгүй байх.</p>	
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу хөтлөөгүйгээс байгууллага зорилгодоо хүрэхэд саад бэрхшээл тулгарах, ашиг алдагдлыг буруу тооцох эрсдэлтэй</p>	
<p>Шийдвэр: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг хуулийн шаардлага, стандарт, дүрэм журамд нийцүүлэн шинэчлэн баталж, мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв</p>	

<u>Илэрсэн асуудал 5</u>	Байгууллагын уламжлалт болон урьдчилан тооцоолсон эрсдэлийг бүртгэж түүнийг бууруулах, гаргахгүй байх эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ байхгүй байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө бага
Бодит байдал: Байгууллагын үйл ажиллагааг төлөвлөхдөө учирч болох эрсдэлүүдийг авч бүртгэж түүнийг бууруулах талаар ярилцдаг боловч баримтжуулаагүй, үнэлгээ хийгдээгүй байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх "Үндсэн үйл ажиллагааны болон санхүүгийн үйл ажиллагааг хянах дотоод хяналттай байна. Дотоод хяналтын бүтэц, ажиллах журмыг дарга батална"	
Асуудлын үндсэн шалтгаан: Эрсдэлийн үнэлгээний ерөнхий ойлголт, ач холбогдол, үнэлгээ хийх арга аргачлалын талаар мэдлэг, мэдээлэлгүй. Эрсдэлийг зөвхөн шаардлагатай үед тодорхойлдог боловч эрсдэлээ бүртгэх үнэлэх, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй байна.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Эрсдэлээ тодорхойлоогүй нөхцөлд байгууллага зорилгодоо хүрэхэд саад бэрхшээл тулгарах, төсөв санхүүгийн хүндрэл учирч хэвийн үйл ажиллагаа алдагдана.	
Шийдвэр: Байгууллагын албан хаагчдад эрсдэлийн талаар ойлголт өгч, дотоод хяналт хариуцсан ажиллагсдыг сургалтад үе шаттай хамруулж, чадавхжуулах -Газрын удирдлага нь байгууллагын хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэхдээ эрсдэлийн чиглэлээр ур чадвар бүхий ажилтан сонгон шалгаруулж авах -Байгууллагын эрсдэлийн түшинг нэг шатлал ахиулан давтамжтай түвшинд шилжих зөвлөмж хүргүүлэх.	

<u>Илэрсэн асуудал 6</u>	Аудитад хамрагдсан 2023-2024 оны хугацаанд байгууллагын дотоод хяналтын чиг үүргийг хариуцах ажилтныг томилоогүй, хяналтын тогтолцоог сулруулж байгууллагын ашигт ажиллагааны үр нөлөөг бууруулж байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө дунд
Бодит байдал: Тус ААТҮГ нь 2023-2024 онд байгууллага дотоод хяналтын чиг үүргийг хэрэгжүүлээгүй, хяналтын ажилтныг томилоогүй байсан нь хяналтын тогтолцоог алдагдуулсан.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтын шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 1.3-т. "Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай байна, Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1-т "Үндсэн үйл ажиллагааны болон санхүүгийн үйл ажиллагааг хянах дотоод хяналттай байна. Дотоод хяналтын бүтэц, ажиллах журмыг дарга батална".	
Асуудлын үндсэн шалтгаан: Дотоод хяналтын ажилтан сонгон шалгаруулаагүй, дотоод нөөц бололцоогоо ашиглан хавсран гүйцэтгэх ажилтан томилоогүй байсан	

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Хяналтгүй нөхцөлд ажиллах болсон нь үйл ажиллагааны уялдаа холбоог сулруулж, үр ашгийг бууруулсан.

Шийдвэр:

Дотоод хяналтын журам боловсруулж, томилогдсон ажилтныг мэргэшүүлэх, хяналтын тогтолцоог хэвшүүлэх арга хэмжээ авна **зөвлөмж** хүргүүлэхээр шийдвэрлэв.

Илэрсэн асуудал 7	Даргын зөвлөлийг 2022.04.30-ны А/24 дугаар тушаалаар байгуулсан боловч ажиллах журмыг тушаалаар баталгаажуулаагүй, зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн асуудал нь (зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн асуудал тодорхойгүй танилцуулга, хурлын тэмдэглэл, шийдвэр гэх мэт) баримтаар нотлогдоогүй.
Асуудлын ангилал	Нөлөө бага
Бодит байдал: Газрын даргын зөвлөлийг 2022 онд тушаалаар байгуулсан боловч ажиллах журмыг батлаагүй, хурлын хэлэлцсэн асуудал, танилцуулга, шийдвэр зэрэг баримт байхгүй. Зөвлөл нь ААТҮГ-ын үйл ажиллагаанд тайлан, үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хяналт тавьж ажиллаагүй, тухайн жилд хийгдэх хөрөнгө оруулалт, их засварын нэгдсэн төлөвлөгөө, төсвийг хэлэлцэж батлуулаагүй, үндсэн хөрөнгийн засвар үйлчилгээг хийх тооцоо судалгаа байхгүй байна	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д "Захирал шаардлагатай мэргэжилтэн, албан тушаалтныг оролцуулан захирлын зөвлөл байгуулан ажиллуулж болох ба зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг захирлын тушаалаар батална.", Сэлэнгэ аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 61 дугаар тогтоолоор баталсан Орон нутгийн өмчийн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Газар нь даргын зөвлөлтэй байх "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хууль болон холбогдох бусад хууль, журамд заасан эрх, үүргийн дагуу үйл ажиллагаа явуулна"	
Асуудлын үндсэн шалтгаан: Зөвлөл нь газрын үйл ажиллагаанд хяналт тавих, төлөвлөгөө, тайланг хэлэлцэх үүргээ хэрэгжүүлээгүй.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Байгууллагаас үзүүлж байгаа ажил, үйлчилгээ нь хууль, тогтоомж, дүрэм журам, эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэртэй нийцэхгүй байх, үйл ажиллагааны болон төсөв санхүүгийн эрсдэл үүссэн.	
Шийдвэр: Цаашид зөвлөлийн ажиллах журмыг баталж, дүрмийн дагуу зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулан хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.	

Илэрсэн асуудал 8

Хүний нөөцийн бодлого, төлөвлөгөөг боловсруулж батлуулаагүй байна.

Асуудлын ангилал	Нөлөө их
Бодит байдал: Тус газрын батлагдсан бүтэц, орон тооны дагуу байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад хүний нөөцийн бодлого, төлөвлөлт алдагдсанаас зүйлшгүй шаардлагатай Захиргаа аж ахуйн албаны санхүү, хүний нөөцийн ажилтнуудыг ажил хавсран гүйцэтгүүлсэн нь нэг талаараа ажил үүргийг нягтруулан цалин хөлсний зардлыг хэмнэж байгаа боловч, нөгөө талаар ажлын ачааллыг хэт нэмэгдүүлж, санхүү, төлөвлөлт, дотоод хяналт, гүйцэтгэлд чанарын доголдол үүсгэж, байгууллагын хэвийн үйл ажиллагаа, үр ашигт сөргөөр нөлөөлж байна	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.2-т "Газрын бүтэц, зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг Аймгийн Засаг дарга тогтооно".	
Асуудлын үндсэн шалтгаан: Батлагдсан бүтэц, орон тоог мөрдөж ажиллуулаагүй, ажлын ачааллыг хэт нэмэгдүүлж, санхүү, төлөвлөлт, дотоод хяналт, гүйцэтгэлд чанарын доголдол үүсгэж байна.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Ажлын ачаалал тэнцвэргүй, гүйцэтгэл буурсан, санхүүгийн төлөвлөлт алдагдаж, байгууллагын үр ашиг, тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлж байна.	
Шийдвэр: <ul style="list-style-type: none"> - Аймгийн Засаг даргаар бүтэц орон тооны дээд хязгаарыг батлуулах, - Хүний нөөцийн бодлого, төлөвлөгөөг боловсруулан баталж, батлагдсан орон тоонд нийцүүлэн ажилтныг томилох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. 	

<u>Илэрсэн асуудал 8</u>	Борлуулсан барааны өртөгт 474,911.1 мянган төгрөгийн Ерөнхий ба удирдлагын үйл ажиллагааны зардлыг бүртгэсэн байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө ихтэй
Бодит байдал: 2023 онд ерөнхий ба удирдлагын цалин 95,030.9 мянган төгрөгийг, интернэтийн холбооны зардал 3,600.0 мянган төгрөгийг, программ хангамжийн зардал 2,100.0 мянган төгрөгийг, шатахууны зардал 14,563.0 мянган төгрөгийг, хангамжийн зардал 9,371.3 мянган төгрөгийг бичиг хэргийн зардал 4,820.0 мянган төгрөгийг, бусдаар гүйцэтгэлийн ажлын зардал 27,272.7 мянган төгрөгийг, нийт 156,757.9 мянган төгрөгийг, 2024 онд ерөнхий ба удирдлагын цалин 101,520.0 мянган төгрөгийг, шатахууны зардал 11,1104.2 мянган төгрөгийг, бусдаар гүйцэтгэлийн ажлын зардал 49,090.9 мянган төгрөгийг татварын торгуульд 156,438.0 мянган төгрөгийг, нийт 318,153.2 мянган төгрөгийг, 2023-2024 онд 474,911.1 мянган төгрөгийг Ерөнхий ба удирдлагын үйл ажиллагааны зардлыг бүртгэсэн байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн 13.1.2-т "албан татвар төлөгчийн албан татвар ногдох орлого олох үйл ажиллагаатай шууд холбогдон гарсан байх"; Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтын Гуравдугаар бүлэг-т "Орлогын дэлгэрэнгүй тайлан нь ... Орлоготой холбогдож гарсан борлуулалтын өртөг болон бусад зардлыг жинхэнэ гарсан хэмжээгээр нь тусгана. Энэхүү тайланд зардлыг чиг үүргээр нь ангилж үр дүнг тооцно"	

<p>Асуудлын үндсэн шалтгаан: Зардлыг зориулалтын дагуу ангилаагүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт болон тайлагналын зааврыг зөрчсөн.</p>
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/ Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал алдагдаж, байгууллагын ашигт ажиллагааг буруу тооцох, татварын зөрчил үүсэх эрсдэлтэй.</p>
<p>Шийдвэр: Борлуулсан барааны өртгийг хууль тогтоомжид нийцүүлэн үнэн зөв тооцож татварын хяналт шалгалтаар үүсэх эрсдэлээс сэргийлж ажиллах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.</p>

<p>Илэрсэн асуудал 9</p>	<p>"ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлангийн орлого, зарлагын 2024 оны төлөвлөгөө"-г боловсруулж батлуулахдаа батлагдсан орон тооны дээд хязгаарт өөрчлөлт орж нэмэгдээгүй байхад өмнөх оноос цалингийн зардлыг 78.9 хувиар, албан томилолтын зардлыг 88.1 хувиар, АО-оос төлөх НДШ-ийн зардлыг 78.8 хувиар, шатахууны зардлыг 128.4 хувиар, татварын зардлыг 139.8 хувиар, маркетинг борлуулалтын зардлыг 93.9 хувиар нэмэгдүүлсэн нь алдагдалтай төлөвлөгөө батлахад голлон шалтгаалсан байна.</p>
<p>Асуудлын ангилал</p>	<p>Нөлөө их</p>
<p>Бодит байдал: Тус газрын орлогын төлөвлөгөөг 2023 онд 722.5 сая төгрөг буюу 26.7 хувиар, 2024 онд 1,560.4 сая төгрөг буюу 35.1 хувиар тасарсан байна. Үндсэн үйл ажиллагааны орлого болох усны борлуулалтын орлого: 2023 онд 2,684.3 сая төгрөг батлагдсанаас 64.7 хувийн буюу 1,963.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй, 26.8 хувиар тасарсан байхад 2024 онд 4,384.3 сая төгрөг буюу 64.7 хувийн гүйцэтгэлтэй, 35.3 хувиар тасарч, төсвийг тооцоо судалгаагүй, үндэслэлгүй боловсруулж, батлуулсан байна. Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг харахад хэмнэсэн мэт харагдаж байвч дүн шинжилгээ хийхэд батлагдсан төсвийг үндэслэлгүй, тооцоо судалгаагүй тооцож төсвийг бодитой төлөвлөж батлуулаагүй байна. 2023-2024 оны зардлын төлөвлөлтөд аудит хийж үзэхэд: 2023, 2024 онд 37-47%-г үндсэн ба нэмэгдэл цалингийн зардал, 5-7%-г байгууллагаас төлөх ЭМ, НДШ, 4-6%-г цахилгаан, 4%-г дулаан, 3-5%-г түлш, шатахуун, тээврийн зардал, 7-17%-г үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, нийт зардлын 60-87%-г эдгээр 6 зардал эзэлж байна. Тодруулбал:</p>	
<p>1. Үндсэн ба нэмэгдэл цалин:</p> <ul style="list-style-type: none"> ✓ 2023 онд 1,315.6 сая төгрөгийн төлөвлөгөөтэй 1,051.9 сая төгрөгийг зарцуулсан (20%-ийн хэмнэлт). ✓ 2024 онд уг зардлын төлөвлөгөө нь 2,352.8 сая төгрөг болж өссөн гүйцэтгэл 1,424.7 саяд хүрч, хэмнэлт 39.5% болсон. ✓ 2024 онд цалингийн зардлын төлөвлөгөөг 1,037.2 сая төгрөг буюу 10%-иар нэмэгдүүлсэн ч, гүйцэтгэл нь 372.7 сая төгрөг буюу 1%-иар буурсан харагдаж байгаа нь үндэслэлгүй төлөвлөснийг харуулж байна. 	
<p>2. Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал:</p> <ul style="list-style-type: none"> ✓ 2023 онд 190.8 сая төгрөгийн төлөвлөгөөтэй 149.0 сая төгрөгийг зарцуулсан (22%-ийн хэмнэлт). ✓ 2024 онд уг зардлын төлөвлөгөө нь 341.2 сая төгрөг болж өмнөх оноос 78.8%-иар өссөн ч гүйцэтгэл 177.2 сая, хэмнэлт 48.1% болсон нь үндэслэлгүй төлөвлөснийг харуулж байна. 	
<p>3. Цахилгаан:</p>	

- ✓ Цахилгааны зардал 2023 онд 226.3 сая төгрөгийн төлөвлөгөөтэй 169.1 сая төгрөгийг зарцуулсан (25.3%-ийн хэмнэлт).
- ✓ 2024 онд уг зардлын төлөвлөгөө нь 219.3 сая төгрөг болж өмнөх оноос 3.1%-иар буурсан, гүйцэтгэл 218.2 сая төгрөг, хэмнэлт 1% байгаа нь хэрэглээнд бодитоор хяналт тавиагүй байна.

4. Дулаан:

- ✓ Дулааны зардал 2023 онд 147.9 сая төгрөгийн төлөвлөгөөтэй 160.7 сая төгрөгийг зарцуулсан (9%-ийн хэтрэлттэй).
- ✓ 2024 онд уг зардлын төлөвлөгөө нь 263.7 сая төгрөг болж өмнөх оноос 64.1%-иар өссөн, гүйцэтгэл 202.6 саяд хүрч, хэмнэлт 23% байгаа нь үндэслэлгүй төлөвлөснийг харуулж байна.

5. Түлш, шатахуун, тээврийн зардал:

- ✓ Түлш, шатахуун зардал 2023 онд 108.0 сая төгрөгийн төлөвлөгөөтэй 87.5 сая төгрөгийг зарцуулсан (19%-ийн хэмнэлттэй).
- ✓ 2024 онд уг зардлын төлөвлөгөө нь 246.5 сая төгрөг болж өмнөх оноос 138.5%-иар өссөн, гүйцэтгэл 121.0 сая төгрөг, хэмнэлт 51% байгаа нь үндэслэлгүй төлөвлөснийг харуулж байна.

6. Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал:

- ✓ Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 2023 онд 598.9 сая төгрөгийн төлөвлөгөөтэй 576.6 сая төгрөгийг зарцуулсан (4%-ийн хэмнэлттэй).
- ✓ 2024 онд уг зардлын төлөвлөгөө нь 327.5 сая төгрөг болж өмнөх оноос 54.7%-иар өссөн, гүйцэтгэл 603.1 сая төгрөг, хэтрэлт 84% байгаа нь төлөвлөгөө, гүйцэтгэлийн зардлыг үндэслэлгүй байгааг харуулж байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Сэлэнгэ аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 61 дугаар тогтоолоор баталсан Орон нутгийн өмчийн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 6.8.1-д "Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд, газрын дүрэм, зорилго, зорилт, бизнес төлөвлөгөөг жилээр болон 3–5 жилээр баталж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, гүйцэтгэлийг хангуулж ажиллана"

Асуудлын үндсэн шалтгаан:

Төсөв, төлөвлөгөө боловсруулахад өмнөх оны гүйцэтгэл, тоон мэдээлэлд тулгуурлаагүй, үр ашгийн тооцоолол хийгдээгүй.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Зардлын хэт төлөвлөлтөөс шалтгаалан алдагдал нэмэгдэж, өр авлагын хэмжээ өсөх, байгууллагын санхүүгийн тогтвортой байдал алдагдах эрсдэлтэй

Шийдвэр:

Цаашид орон нутгийн өмчийн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын төлөвлөгөөг өнгөрсөн гүйцэтгэл болон бодит нөхцөлд тулгуурлан боловсруулж, үндэслэлтэй, хэрэгжихүйц байдлаар батлуулж ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

<u>Илэрсэн асуудал 10</u>	Урьдчилж төлсөн зардлын тооцоо дансанд 2017 онд бүртгэсэн 2,243.2 мянган төгрөгийн тооцоог барагдуулаагүй байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө ихтэй
Бодит байдал:	2017 онд урьдчилж төлсөн зардлын тооцоогоор бүртгэгдсэн 2,243.2 мянган төгрөгийг өнөөг хүртэл барагдуулаагүй, бүртгэлийн дансанд удаан хугацаагаар үлдсэн нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдалд нөлөөлж байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах..." гэсэн заалтыг хангахгүй байна.

Асуудлын үндсэн шалтгаан:

Урьдчилж төлсөн зардлын гүйцэтгэлд хяналт тавиагүй, тооцоог хугацаанд нь барагдуулах арга хэмжээ аваагүй.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/

Санхүүгийн тайлангийн бодит байдал алдагдаж, байгууллагын хөрөнгийн зохистой байдлыг буруу илэрхийлж байна.

Шийдвэр:

урьдчилж төлсөн зардлын бүртгэлд хяналт тавих, хугацаа хэтэрсэн дүнг тогтмол шалгаж, үндэслэлтэй зардлыг барагдуулж, үндэслэлгүй дүнг тайлангаас хасах, мөн ижил төрлийн зөрчил дахин үүсэхээс сэргийлэн дотоод хяналтын тогтолцоог сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх **зөвлөмж** хүргүүлэхээр шийдвэрлэв.

Илэрсэн асуудал 12	Нийгмийн даатгалын санд төвлөрүүлэх шимтгэлийн хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулаагүйгээс ажилчдын ХЧТА болон жирэмсэн амаржсаны тэтгэмжид 2023, 2024 онд байгууллагаас нийт 29,223.2 мянган төгрөгийг олгосон нь алдагдлыг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна.
Асуудлын ангилал	Нөлөө их
Бодит байдал: Тус газрын цалингийн зардалд аудит хийж үзэхэд: 2023-2024 онд нийт зардлын 37-47%-г үндсэн ба нэмэгдэл цалингийн зардал , 5-7%-г байгууллагаас төлөх ЭМ, НДШ эзэлж байна. НДШ-ийн өр төлбөр 2023 онд 1,028.5 сая төгрөг байсан бол 2024 онд 1,221.1 сая төгрөг болж 192.6 сая төгрөг буюу 18.7%-иар өссөн. Үүнтэй холбоотойгоор ажилтан албан хаагчдад төрөөс олгох тэтгэмжийг хуулийн дагуу олгож чадахгүйд хүрсэн байна. 2023 онд ХЧТА 10 ажилтанд олгох 2.9 сая төгрөгийг, 2 жирэмсэн, амаржсан эхийн тэтгэмж 9.6 сая төгрөгийг, 2024 онд ХЧТА 7 ажилтанд олгох 1.2 сая төгрөгийг, 2 жирэмсэн, амаржсан эхийн тэтгэмж 10.0 сая төгрөгийг, нийт 23.7 сая төгрөгийг цалингийн сангаас олгож батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулж, цалингийн зардлыг нэмэгдүүлсэн байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмж, хөнгөлөлт, шимтгэлийн төлбөр: 2.1.1-т "хөдөлмөрийн чадвар түр алдсаны", 2.1.2. "жирэмсний болон амаржсаны", 5 дугаар зүйлийн 5.1-т "Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсан хугацааны ажлын эхний таван өдрийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг ажил олгогчоос, зургаа дахь өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх, эсхүл хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авах эрх үүсэх хүртэл хугацааны тэтгэмжийг тэтгэмжийн даатгалын сангаас тус тус олгоно"	
Асуудлын үндсэн шалтгаан: Төсвийн төлөвлөлт, удирдлага хангалтгүй байснаас нийгмийн даатгалын өрийг бууруулах арга хэмжээ аваагүй.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Нийгмийн даатгалаас олгох тэтгэмжийг цалингийн сангаас олгосноор үндсэн цалингийн зардлыг нэмэгдүүлж, сангийн зориулалт алдагдан, байгууллагын алдагдал өссөн.	

Шийдвэр:

Цаашид Нийгмийн даатгалын өрийг тооцон баталгаажуулж, төлбөрийн хуваарь гарган, зохих байгууллагатай хамтран шийдвэрлэх **зөвлөмж** хүргүүлэхээр шийдвэрлэв.

Илэрсэн асуудал 13	Сэлэнгэ аймгийн хэмжээнд тоолууржуулалтын дундаж 69.7 хувьтай хангалтгүй үзүүлэлтэй байгаа нь усны орлогыг нэмэгдүүлэх боломжийг алдаж байна.
Асуудлын ангилал	Нөлөө их
<p>Бодит байдал: Сэлэнгэ цэнгэг ус ААТҮГ-ын 2023 оны орлого болоогүй усны хэмжээ орон нутгийн дунджаас 25.2%, бүсийн дунджаас 12.0%-иар өндөр байна Олборлосон усны хэмжээг сүүлийн 4 жилийн үзүүлэлтээс харахад тогтвортой байгаа нь үйлдвэрлэлийн хүчин чадал өөрчлөгдөөгүйг илтгэж байна.</p> <ul style="list-style-type: none"> • Борлуулсан ус 2022 оноос огцом буурч, 2023 онд хамгийн доод түвшинд хүрсэн ч 2024 онд бага зэрэг нэмэгдсэн байна. • Орлого болоогүй ус 2022 онд огцом нэмэгдэж, 2023, 2024 онд буурсан ч 2021 оныхоос өндөр хэвээр байна. Энэ нь үйл ажиллагааны доголдол байгааг харуулж байна. • Усны алдагдлын хувь 2021 онд 2.87% байсан бол 2023 онд 45.29% болж хамгийн өндөр үзүүлэлттэй бөгөөд 2024 онд 25.06% болж буурсан нь тодорхой арга хэмжээ авсан ч, нөхцөл байдлыг сайжраагүй байна. • 2024 онд ҮААНБ-ын тоолууржуулалт өндөр (91.3%) байгаа ч өмнөх оноос буурсан байна. Айл өрхийн тоолууржуулалт 2023 онд 41.9% байсан бол 2024 онд 48.2% болж өссөн ч улсын дунджаас 50.7%-иар бага, 2023 оны орлого болоогүй усны хэмжээ орон нутгийн дунджаас 25.2%, бүсийн дунджаас 12.0%-иар өндөр байгаа нь орлого бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлж байна. <p>Усны алдагдал сүүлийн жилүүдэд буурч байгаа ч 2024 онд хамгийн бага алдагдалтай гэхэд ус үйлдвэрлэлийн 25.06 хувь буюу 512,948.3-1,003,594.5 мянган төгрөгийн алдагдалтай байна. Цаашид тоолуургүй хэрэглээтэй ААНБ, сургууль, цэцэрлэгүүдийн бодит хэрэглээг судалж, задгай хэрэглээнд хяналт тавьж, заавал тоолууржуулах бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна. Задгай хэрэглээтэй айл өрх 2023 онд 2,083 байсан бол 2024 онд 2,002 болж 81 өрх буюу 3.9%- иар буурсан байна.</p>	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/: Хот, суурины ус хангамж ариутгах татуургын ашиглал үйлчилгээг зохицуулах хорооны тогтоолоор батлагдсан 2024 оны 23 дугаар “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээний тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 3.4.7-д Тусгай зөвшөөрөл сунгуулах аж ахуйн нэгж байгууллагуудын хувьд айл өрх, аж ахуйн нэгжүүдийг 80-аас доошгүй хувь тоолууржуулсан байх буюу тоолууржуулалт хийх график, төлөвлөгөөтэй байх;</p>	
<p>Асуудлын үндсэн шалтгаан: Тоолуургүй хэрэглээ өндөр, усны алдагдлын шалтгааныг тодорхойлоогүй, дотоод хяналт хангалтгүй.</p>	
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Усны алдагдал өндөр түвшинд байгаа нь байгууллагын орлогыг бууруулж, үйл ажиллагааны үр ашигт сөргөөр нөлөөлж байна.</p>	
<p>Шийдвэр:</p>	

Цаашид Усны алдагдлыг бууруулах арга хэмжээг төлөвлөж, алдагдлыг илрүүлэх техник хэрэгслээр хангах, тоолуургүй хэрэглэгчдийг үе шаттайгаар тоолууржуулах бодлого хэрэгжүүлэх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Илэрсэн асуудал 14	2024 онд задгай хэрэглээний гэрээтэй Сүхбаатар сумын 721 өрхийн 885 иргэний бүртгэлд хамруулаагүйгээс 198,874.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэх боломжийг алдаж байна.
Асуудлын ангилал	Нөлөө их

Бодит байдал:

1. Улсын хэмжээнд үйлдвэр ААНБ болон айл өрхийн тоолууржуулалт 96.1% байгаа бол Төвийн бүс 88.2% буюу улсын дунджаас 7.9%-иар бага, Сэлэнгэ аймгийн хувьд 2023 онд үйлдвэр ААНБ-ын тоолууржуулалт 92.6 хувиас 2024 онд 91.3% болж өмнөх оноос 1.3 хувиар буурсан бол айл өрхийн тоолууржуулалт 2023 онд 41.9%, 2024 онд 48.2% болж 6.3 хувиар өссөн үзүүлэлтэй, нийт тоолууржуулалтын дундаж 69.7 хувьтай байгаа нь улсын дундажаас 26.4%-иар бага байгаа нь айл өрхийн тоолууржуулалт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Үйлдвэр ААНБ 2023 онд нийт 406 ҮААНБ хэрэглэгч байснаас 92.6% нь тоолууртай, 7.4% нь тоолуургүй, 2024 онд хэрэглэгчийн тоо 414 болж өссөн тоолууртай хэрэглэгч 378 (91.3%), тоолуургүй хэрэглэгч 36 (8.7%) байна. Давхардсан тоогоор 72 хэрэглэгч тоолуургүй байгаагаас улсын төсвийн 8, хувийн хэвшлийн 60, эзэнгүй 4 объект байна.

Үүнд:

- Онцгой байдлын газар,
- Цагдаагийн газар,
- 5-12 жилийн сургууль,
- АБ сум Сургууль,
- АБ сум Эмнэлэг,
- АБ сум Цэцэрлэг,
- АБ сум Музей,
- АБ сум Нийгмийн даатгал,
- Алтан тариа,
- Энэрэлт үйлс,
- Каток,
- Т&Т ресторан,
- Залуус кафе,
- Алтан булаг төв,
- Корпус халуун ус,
- АБ сум Хуушуур хаус,
- АБ сум Буянт рашаан эмийн сан,
- АБ сум Искра зоогийн газар,
- АБ сум халуун ус,
- АБ сум Дельфин зоогийн газар зэрэг газрууд болон дэлгүүр, мухлаг, угаалгын газар гэх мэт

2023 онд айл өрхийн 3588 хэрэглэгч байсан бол 2024 онд 3868 болж нэмэгдсэн. 2024 онд тоолууртай хэрэглэгчид 6.3%-иар нэмэгдсэн байна.

2. Тус газрын бүртгэлд 2024 онд задгай хэрэглээний гэрээтэй Сүхбаатар сумын 721 өрхийн 1276 ам бүлийг аудитын явцад тулган баталгаажуулахад 721 өрхөд 2161 ам бүл бүртгэлтэй байна. Энэ нь усны задгай хэрэглээнд тавих хяналт хангалтгүй байгаагаас 885 иргэний 198,874.2 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлэх боломжийг алдсан байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Барилга, Хот байгуулалтын сайдын 2018 оны 192 дугаар тушаалын хавсралт "Ус хангамж, ариутгах татуургын системийн техник ашиглалтын дүрэм"-ийн 2.11.2. Орон сууцны болон бусад хэрэглэгчдэд ундны цэвэр усыг зүй зохистой ашиглах нөхцөл бүрдүүлэхийн тулд ашиглалтын байгууллага, хэрэглэгчдийг усны хэмжүүр суурилуулахыг шаардах, хэрэглэгчдийн усны зарцуулалтад системтэйгээр хяналт тавих.

Асуудлын үндсэн шалтгаан:

Задгай хэрэглээтэй өрхийн ам бүлийн бүртгэлийг 2023, 2024 онд шинэчлээгүй, гэрээ байгуулахдаа мэдээлэл дутуу бүртгэсэн.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Усны бодит хэрэглээ бүрэн хянагдаагүй, орлого бүрдүүлэлт тасалдаж, байгууллагын санхүүгийн үр ашиг буурсан.

Шийдвэр:

Цаашид задгай хэрэглээтэй айл өрхийн ам бүлийн судалгааг шинэчлэх баталгаажуулах ажлыг төлөвлөгөөтэйгөөр зохион байгуулж, үр дүнг тайлагнах **зөвлөмж** хүргүүлэхээр шийдвэрлэв.

5. АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар нийт 842,915.6 мянган төгрөгийн 15 зөрчил илрүүлснээс 2,500.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 612,318.2 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах 228,097.4 мянган төгрөгийн 9 зөвлөмж өглөө.

- Албан томилолтын зардалд 2023 онд 500.0 мянган төгрөг, 2024 онд 2,000.0 мянган төгрөг, нийт **2,500.0** мянган төгрөгийн зарцуулалтыг нотлох хангалттай, зохистой анхан шатны бүрдэл хангасан баримтгүй байна.
- Аймгийн Засаг даргаар батлуулсан санхүүгийн төлөвлөгөөний албан томилолтын зардлыг 2023 онд 8,476.0 мянган төгрөгөөр, 2024 онд 12,659.6 мянган төгрөгөөр, нийт **21,135.6** мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.
- Санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуаагүй, хүчин төгөлдөр бус **114,028.3** мянган төгрөгийн ажил гүйлгээний зарцуулалтыг 2023 оны бүртгэл тайланд тусгасан байна.
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын үйл ажиллагааны онцлог, стандарт, хууль, тушаал, зааварт нийцэхгүй байна.
- Байгууллагын уламжлалт болон урьдчилан тооцоолсон эрсдэлийг бүртгэж түүнийг бууруулах, гаргахгүй байх эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх арга хэмжээний тогтолцоо төлөвшөөгүй байна.
- Аудитад хамрагдсан 2023-2024 оны хугацаанд байгууллагын дотоод хяналтын чиг үүргийг хариуцах ажилтныг томилоогүй хяналтын тогтолцоог сулруулж байгууллагын ашигт ажиллагааны үр нөлөөг бууруулж байна.

- Даргын зөвлөлийг 2022.04.30-ны А/24 дугаар тушаалаар байгуулсан боловч ажиллах журмыг тушаалаар баталгаажуулаагүй, зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн асуудал нь тодорхойгүй хурлын ирц, танилцуулга, хурлын тэмдэглэл, хурлаас гарсан шийдвэрийг албажуулаагүй байна.
- Хүний нөөцийн бодлого, төлөвлөгөөг боловсруулж батлуулаагүй авч хэрэгжүүлсэн арга хэмжээ тодорхойгүй байна.
- 2024 оны санхүүгийн орлого, зарлагын нэгдсэн төлөвлөгөө"-г боловсруулж батлуулахдаа батлагдсан орон тооны дээд хязгаарт өөрчлөлт ороогүй байхад өмнөх оноос цалингийн зардлыг 78.9 хувиар, албан томилолтын зардлыг 88.1 хувиар, АО-оос төлөх НДШ-ийн зардлыг 78.8 хувиар, шатахууны зардлыг 128.4 хувиар, татварын зардлыг 139.8 хувиар, маркетинг борлуулалтын зардлыг 93.9 хувиар нэмэгдүүлсэн нь алдагдалтай төлөвлөгөө батлахад голлон шалтгаалсан байна.
- Борлуулсан барааны өртөгт **474,911.1** мянган төгрөгийн Ерөнхий ба удирдлагын үйл ажиллагааны зардлыг бүртгэсэн байна.
- Нийгмийн даатгалын санд төвлөрүүлэх шимтгэлийн хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулаагүйгээс ажилчдын ХЧТА болон жирэмсэн амаржсаны тэтгэмжид 2023, 2024 онд байгууллагаас нийт **29,223.2** мянган төгрөгийг олгосон нь алдагдлыг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн байна.
- Сэлэнгэ аймгийн хэмжээнд тоолууржуулалтын дундаж 69.7 хувьтай хангалтгүй үзүүлэлтэй байгаа нь усны орлогыг нэмэгдүүлэх боломжийг алдаж байна.
- 2024 онд задгай хэрэглээний гэрээтэй Сүхбаатар сумын 840 өрхийн 883 иргэний бүртгэлд хамруулаагүйгээс **198,874.2** мянган төгрөгийн орлого төвлөрүүлэх боломжийг алдаж байна.
- Урьдчилж төлсөн зардлын тооцоо дансанд 2017 онд бүртгэсэн **2,243.2** мянган төгрөгийн тооцоог барагдуулаагүй байна.

6.АУДИТЫН ДҮГНЭЛТ

Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тайлбар
Хангалтгүй	Засаглал эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь “эхлэлийн буюу 1-р түвшин”-д байна гэж үзсэн. Аудитаар илэрсэн асуудлуудын 80%-иас дээш нь “нөлөө ихтэй” гэж үзсэн.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт компани /ОНӨААТҮГ/-ийн засаглалыг хөгжүүлэх, сайжруулах чиглэлээр үр нөлөө бүхий арга хэмжээг тусгаж, хэрэгжүүлээгүй байна.

- Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд зорилтот түвшинг байгууллагын 3 жилийн хэтийн зорилттой уялдуулж төлөвлөөгүй, аймгийн ОНӨГ-аар хянуулж, дүгнэлт гаргуулаагүй байна.
- Сэлэнгэ Цэнгэг Ус ААТҮГ-ын 2023-2024 онуудын орлогын төлөвлөгөө 73.3-64.8 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.
- Тус газрын 2023, 2024 оны санхүүгийн орлого, зарлагын нэгдсэн төлөвлөгөөний зорилтот түвшинг үйлдвэрлэлийн үр дүнгээр алдагдал хүлээхээр тодорхойлон батлуулсан бөгөөд 2023 онд тооцоолсон алдагдлыг 864,208.7 мянган төгрөг, 2024 онд 560,225.5 мянган төгрөг байхаар тооцсон боловч 2023 онд тооцоолсон алдагдлыг 258,251.0 бууруулсан бол 2024 онд 175,294,1 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн нь аймгийн Засаг даргаар батлуулсан санхүүгийн төлөвлөгөөг мөрдөн ажиллаагүй байна.
- Тус газар нь өнөөгийн бүтэц, зохион байгуулалтаар бие даан үйл ажиллагаа явуулах нөхцөл, боломжгүй байдалд хүрсэн байна.
- Санхүүгийн орлого, зарлагын нэгдсэн төлөвлөгөөг бодитоор төлөвлөхгүй байгаагаас орлогын төлөвлөгөө 2023 онд 26.7 хувиар, 2024 онд 35.2 хувиар тус тус тасарсан нь төлөвлөсөн орлогыг бүрэн төвлөрүүлэхгүйгээс алдагдлыг нэмэгдүүлэх шалтгаан болж байна.
- Гүйцэтгэх засаглалын тавих дотоод хяналт шалгалтын тогтолцоо бүрдэж төлөвшөөгүйгээс Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитаар 2023 онд “Хязгаарлалттай”, 2024 онд “Сөрөг” дүгнэлт авсан нь байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны сахилга бат, дотоод хяналт сул байгааг илэрхийлж байна.
- Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу босго үнийг баримтлан сонгон шалгаруулалтыг цахимаар нээлттэй, ил тод зарлаж явуулахгүй байна.

Иймд дээрх дүгнэлтүүдийг үндэслэн газрын 2023-2024 оны үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын хүрээнд байгууллагын засаглал, санхүүгийн үйл ажиллагаанд хууль, тогтоомж, дүрэм журмыг хэрэгжүүлдэггүй. Санхүүгийн сахилга бат муу, он дамнасан өр төлбөр, авлага барагдуулах тал дээр бодитой ажил, арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулдаггүй зэрэг алдаа зөрчлийг үндэслэн “Хангалтгүй” гэсэн дүгнэлтийг өгч байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

- Орлого, зардлын төлөвлөгөөг бодитой тооцож, алдагдалтай төсөв батлуулахгүй байх, дотоод хяналтыг бэхжүүлэн, санхүүгийн сахилга батыг сайжруулах.

- Он дамжсан өр, авлагыг барагдуулах ажлын хэсэг байгуулан тусгайлсан төлөвлөгөө гарган, авлага барагдуулах урамшуулал системийг боловсруулан үр дүн гарган ажиллах.
- Тоолуургүй хэрэглэгчдийн дэлгэрэнгүй судалгааг гарган хяналт тавих, тоолууржуулах ажлыг эрчимтэй зохион байгуулах, тоолуурын хэвийн ажиллагаанд стандарт хэмжил зүйн байгууллагатай хамтран хяналт тавих.
- Хүний нөөцийн бодлого, төлөвлөгөөг боловсруулж мэргэжлийн байгууллага, албан хаагчдаас бүрдсэн комисс ажиллуулж ажлын байрны чиг үүргийн шинжилгээ хийж, чиг үүргийн давхардал хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэхэд газрын бүтэц, орон тоо, зохион байгуулалтыг оновчтой болгож, ажлын байр бүрд шаардлагатай мэдлэг, ур чадвартай ажилтныг томилох, тус ажилтнуудыг сургалт мэдээллээр хангаж, цалин урамшууллын системийг ажлын гүйцэтгэл үр дүнтэй уялдуулан тооцож байх
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг байгууллагын үйл ажиллагааны онцлог, стандарт, хууль, тушаал, зааварт нийцүүлэн шинэчлэн боловсруулж баталгаажуулан мөрдөж санхүүгийн сахилга батыг сайжруулах
- Байгууллагын уламжлалт болон урьдчилан тооцоолсон эрсдэлийг бүртгэж түүнийг бууруулах, гаргахгүй байх эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх арга хэмжээний тогтолцоо төлөвшүүлж ажиллах.
- Байгууллагын дотоод хяналт хариуцсан ажилтныг чиг үүргийг тодорхой болгож үйлдвэрлэлийн үйл ажиллагааны алдагдлыг бууруулах үр нөлөөг дээшлүүлэх.
- Байгууллагын даргын зөвлөлийн ажиллах журмыг нэн яаралтай боловсруулан тушаалаар баталгаажуулж, зөвлөлийн хурлын шийдвэрийг хурлын тэмдэглэл, хурлаас гарсан шийдвэрийг албажуулж хэвших
- Задгай хэрэглээний гэрээтэй айл өрхийн бүртгэлд тавих хяналтыг сайжруулах замаар усны орлогын хэмжээг нэмэгдүүлж ажиллах.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:
ДОТООД АУДИТОР

ДОТООД АУДИТОР

ТАЙЛАН ХЯНАСАН:
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА

ТАНИЛЦСАН:
ЦЭНГЭГ УС ААТҮГ-ЫН ДАРГА

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

